ШИВЭЭГОВЬ СУМЫН МЭДЭЭ

2023 ОНЫ 02 ДУГААР САРЫН 04-НӨӨС 02 ДУГААР САРЫН 16-НЫ ХООРОНД ХИЙГДСЭН АЖЛУУДААС

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Шивээговь сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хурлыг 100 хувийн ирцтэйгээр зохион байгуулж, 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн боловсруулж, 3 зорилтын хүрээнд 11 дэд бүлгийн 24 арга хэмжээг баталлаа.

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2023 оны Цэргийн бүртгэл нь 01 дүгээр сарын 09-нөөс 01 дүгээр сарын 31-нийг хүртэл улс нийтээр зохион байгуулагдсан. Цэргийн шинэчилсэн бүртгэлд сумын 1, 2-р багийн нийт 18-50 насны 794 хүн бүртгэгдэхээс 523 хүн бүртгэгдэж, 271 хүн бүртгэлд хамрагдаагүй байна.

2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Цэргийн шинэчилсэн бүртгэлийн тайлан нэгтгэлийг 2-р багийн Засаг дарга, Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн нар Цэргийн штаб дээр хүргүүлэн, тайлагнаад байна.

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2023 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Сумын 2-р багийн иргэн Ч.Амартүвшингийн гэр бүлийн санаачлагаар зохион байгуулагдсан "ДЭЭЛТЭЙ МОНГОЛ-2023" үндэсний хувцасны арга хэмжээ амжилттай зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээнд 6 баг буюу 22 иргэд оролцож, монгол үндэсний хувцас хэрэглэлийг сурталчлан таниулж, үндэснийхээ хувцсаар гоёж, өв соёлоо сурталчлан түгээсэн арга хэмжээ боллоо.

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын Улаан загалмайн анхан шатны хорооноос зохион байгуулж буй "ДУЭТ ДУЭЛЬ 2023" хос дууны уралдаан амжилттай зохион байгуулагдлаа. Уралдаанд 5 хос буюу 10 оролцогч оролцож, өөрсдийн авъяас чадвараараа өрсөлдөж дуу хөгжмийг эгшиглүүллээ.

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС ЗОХИОН БАЙГУУЛСАН "ЭЛБЭГ ДЭЛБЭГ ЦАГААН САР 2023" ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА 2023 ОНЫ 02 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР СУМЫН ХЭМЖЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.

Үзэсгэлэн худалдаанд хувиараа хөдөлмөр эрхлэгчид, аж ахуй нэгжүүд оролцсон бөгөөд 40 гаруй нэр төрөл бүхий бүтээгдэхүүнээр 10 гаруй хөдөлмөр эрхлэгч нар сумынхаа зон олонд бүтээгдэхүүнээ суртчилан таниулсан арга хэмжээ боллоо.

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 17-р хуралдаан хуралдлаа. Уг хуралдаанаар:

1. Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах хорооны бүрэлдүүнийг өөрчлөх тухай
2. Ажлын хэсэг байгуулах тухай
3. Авто зам ашиглаж хамтран ажиллах гэрээний хүрээнд хийгдсэн ажлын танилцуулга
4. Хурлын Зөвлөл байгуулах тухай
5. Ажлын хэсгийн гишүүгийг өөрчлөх тухай
6. Сумын ИТХ-д суудалтай намд олгох дэмжлэг зардлыг зарцуулах журмын төсөл
7. Шивээговь сумын ИТХ-ын шагналаар шагнуулах тухай
8. Орон нутгийн Хурлын нөхөн сонгуулийг товлон зарлах тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэн хуралдлаа.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР

Аймгийн Хөдөө аж ахуйн газарт 7 хоног бүрийн 3 дах өдөр бод, бог малын хорогдолын мэдээг хүргүүлж байна. Өнгөрсөн 7 хоногийн байдлаар сумын хэмжээнд 2 үхэр, 8 ямаа хорогдсон байна. Өвөлжилтийн хүгдрэл буурсантай холбогдуулан хорогдол харьцангуй бууралттай байна.

ОРОН НУТАГ ХӨГЖЛИЙН САНГИЙН ТАЛААР

ОНХС-ийн шилэн дансны мэдээллийг цаг тухай бүрт нь оруулж, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг ил тод нээлттэй байлгах үүднээс өнгөрсөн оны мэдээллийг нөхөн оруулаад байна.

2023 оны 02 дугаар сарын 08, 09-ний өдөр “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс зохион байгуулагдсан Аймаг, сумын албан хаагчдадзориулсан удирдлага мэдээллийн системийн цахим сургалтад төрийн сангийн мэргэжилтэн болон ОНХС хариуцсан мэргэжилтэн нар хамрагдаад байна.

БОЛОВСРОЛЫН ТАЛААР

Байгууллагын тохижилт, суралцагчдын тав тухтай орчныг бий болгох үүднээс “ТОХИЛОГ ОРЧИН АМЖИЛТЫН ҮНДЭС” АНГИ, КАБИНЕТ ТОХИЖУУЛАХ УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА. ЕБС-ийн Захирлын тушаалаар батлагдсан 5-с доошгүй бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 5 шалгуур үзүүлэлтээр дүгнэж кабинет, лабораторын байгуулалт, анги танхимын тохижилт гэсэн чиглэлээр шилдэгийг тодруулан шалгаруулаад байна.

“ЦАХИМ СУРГАЛТЫН ТАНХИМ”-ыг нээн, интернэтээр ханган, орчин нөхцлийг бүрдүүлэх, “Сургалтын тоног төхөөрөмж, нөхөн хангалт”-ын зардлаар 34ш таблетаар хангах ажлыг зохион байгууллаа. Мөн “ЦАХИМ СУРГУУЛЬ – ЦАХИМ СОНГОН 10-р анги” 2022-2023 оны хичээлийн жилд 10-р ангийн суралцагчдын сонгон судлах хичээлүүд суралцагчдын хичээл сонголтын тооноос шалтгаалан цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулагдаж байгаа. Цахим сургуулийн хамрагдалт, үр дүнг сайжруулах зорилгоор сургуулийн захиргаа, эцэг эх, суралцагчийн гурвалсан уулзалт, арга хэмжээг 02 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулж, гурвалсан гэрээ байгуулсан.



ГБХЗХГ, БШУГ-ын дарга нарын хамтарсан тушаалаар "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ"-ээр ГБХЗХГазрын албан хаагчид манай сургуульд 2023 оны 02 дугаарын 06-нд ирж ажиллаа.

"ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН"-ИЙН ХЭРЭГЖИЛТ, "ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БАГ"-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД:

- Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 32 хүүхдийн эргэн хяналт, дэмжлэг

- Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ

- Ахлах дунд ангийн нийт 325 хүүхдэд #Ye тэнгийн дээрэлхэлт, дарамт шахалт, #Цахим зохистой хэрэглээний сургалт

- Сургуулийн багш албан хаагчдад #Багшийн ёс зүй, #Хүүхэд хамгааллын багийн чадавхижуулах сургалт

- Эцэг эх асран хамгаалагчдад хүүхэддээ тавих хараа хяналтаа сайжруулах, асран хамгаалж төлөвшүүлэх үүргээ биелүүлэх мөн хүүхдийн эрхийн зөрчил гарахад хэнд хандаж эрх зүйн туслалцаа авах #Хүүхэд хамгааллын захидлыг хүргүүлж ажилласан.

Үйл ажиллагаанд нийт багш, ажилчид болон суралцагчид хамрагдаж, мэдлэг мэдээллээр хангагдлаа.

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.